

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

2020 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны  
хөгжлийн үзэл баримтлал батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. ““Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын доор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /УХүрэлсүх/-т үүрэг болгосугай:

1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бус нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох;

3/Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас баталсан дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг энэ хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэх арга хэмжээ авах;

4/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж байх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоолыг 2020 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг